

“НЭГ БҮС, НЭГ ЗАМ”-ЫН ХҮРЭЭНД ӨВӨР МОНГОЛООС МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДААНЫ ТУХАЙД¹

Наран

Өвөр Монголын их сургуулийн

Монгол судлалын төвийн судлаач, доктор (Sc.D), профессор

E-mail хаяг: ndnal@sina.com

Хураангуй. Өвөр Монголын Өөртөө Засах Орон болон Монгол Улсын хоорондох хоёр талт эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа нь Хятадын “Нэг бүс, нэг зам” хөтөлбөр хийгээд Монгол Улсын “Хөгжлийн зам” санаачилгын хүрээнд жинтэй байрыг эзэлдэг билээ. Уг өгүүлэлд Өвөр Монголын Өөртөө Засах Орон болон Монгол Улсын үндсэн орчин нөхцөл, хоёр орны өнөөгийн хөрөнгө оруулалтын байдал, талуудын хамтын ажиллагаанд оршиж буй эрсдэлийн талаар үнэлгээ хийн, цаашид хэрхэн сайжруулах арга замын тухайд зөвлөхийг зорилоо.

Түлхүүр үгс: Өвөр Монголоос Монголд оруулж буй хөрөнгө оруулалт, нэг бүс нэг замын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын үнэлгээ, хамтын ажиллагааны эрсдэл

¹ Энэхүү өгүүллийг БНХАУ-ын Боловсролын яамны Философи ба нийгмийн шинжлэх ухааны судалгааны суурь судалгаа – “БНХАУ-ын Нэг бүс, нэг зам стратеги ба Монголын Хөгжлийн зам санаачлагын уялдааг ахиулах нь” төслийн (дугаар:16JJJGJW008) үр дүнд нийтлэв. 本调研为中国教育部哲学社会科学重点研究基地重大项目《中国“一带一路”战略与蒙古国“发展之路”倡议对接推进研究》(批号16JJJGJW008)阶段性成果。



Монгол Улс бол БНХАУ-ын хамгийн ойрын хөрш бөгөөд “Нэг бүс, нэг зам”-ын дагуух чухал улс, мөн “Нэг бүс, нэг зам” санаачилгыг хамгийн түрүүнд дэмжиж оролцсон улсын нэг юм. Харин Өвөр Монголын Өөртөө Засах Орон бол “Нэг бүс, нэг зам” санаачилгыг хэрэгжүүлэх Монгол, Хятад, Оросыг холбосон эдийн засгийн коридорын гол нутаг, ялангуяа “Нэг бүс, нэг зам” хийгээд “Хөгжлийн зам” санаачилгыг хэрэгжүүлэхэд чухал байр суурь эзэлдэг нутаг орон юм.

Сүүлийн жилүүдэд иж бүрэн стратегийн түншлэлээр дамжин Монгол, Хятад хоёр орны бодит хамтын ажиллагаа тасралтгүй өргөжин бэхжиж байна. Тухайлбал, 2014-2018 оны хооронд Монгол, Хятад хоёр улсын төрийн тэргүүд олон удаа уулзаж, хоёр орны хооронд 1 тэрбум долларын 73 хамтын ажиллагааны гэрээ байгуулагджээ.

Хоёр улсын дээд хэмжээний айлчлал, зөвшилцөлд хүрсэн чухал зүйлс гэвэл, 2014 оны 8 дугаар сард БНХАУ-ын дарга Ши Жиньпин Монгол Улсад төрийн айлчлал хийж, хоёр тал харилцан стратегийн түншлэлийн харилцаагаа өргөжүүлэн, Хятадаас 1.3 тэрбум юаний буцалтгүй тусламж үзүүлснээс гадна, 1 тэрбум ам.долларын эдийн засгийн хамтын ажиллагааны 26 баримт бичигт гарын үсэг зурав. 2016 оны 7 дугаар сард БНХАУ-ын Ерөнхий сайд Ли Кэчянь Монгол Улсад айлчилсан бөгөөд Хятадаас Монголын талд 1.5 тэрбум долларын хөнгөлөлттэй зээлийг хамарсан 15 хамтын ажиллагааны гэрээг хоёр тал байгуулсан байна. 2017 оны 5 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат “Нэг бүс, нэг зам” олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний уулзалтад оролцон Хятадад айлчлахад талууд “Монгол, Хятадын Засгийн газрын “Нэг бүс, нэг зам” болон “Хөгжлийн зам” санаачилгыг уялдуулах хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд 1.5 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн төслийг багтаасан 21 баримт бичигт гарын үсэг зуржээ. 2018 оны 4 дүгээр сард Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Хятадад айлчилсан бөгөөд хоёр тал эдийн засаг, худалдаа, хүмүүнлэг, үйлдвэрлэлийн нөөц, байгаль

орчин хамгаалал чиглэлээр 450 орчим сая ам.долларын хамтын ажиллагааны 11 баримт бичигт гарын үсэг зурав.

Эдгээрээс гадна, сүүлийн хоёр жилд Монгол Улсад тулгараад буй эдийн засгийн хямралын эсрэг эдийн засгийн сэргээн босголтын төлөвлөгөөг Хятад улс идэвхтэй дэмжиж, “Олон улсын валютын сан”-гийн 5.5 тэрбум ам.долларын төлөвлөгөөний хүрээнд БНХАУ-ын Ардын банк, Монгол банкны хооронд нийт 15 тэрбум юанийн (2.2 тэрбум ам.долларын) хоёр талт своп хэлэлцээрийн гэрээг гурван жилийн хугацаатайгаар байгуулсан юм.

Одоогоор Монгол, Хятад хоёр улс дээр дурдсан гэрээний тусгай хэрэгжилтийг хангахын тулд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Ялангуяа, Өвөр Монгол нь хоёр улсын газар зүйн байрлал, соёлын ижил төстэй байдал хийгээд эдийн засгийн харилцан нөхөж болох давуу талд түшиглэн, Монгол Улс дахь хөрөнгө оруулалт, худалдаагаа тасралтгүй өргөжүүлж, Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж байна.

1. Өвөр Монголын Өөртөө Засах Орон хийгээд Монгол Улсын үндсэн нөхцөл байдал

Өвөр Монголын Өөртөө Засах Орон

Өвөр Монголын Өөртөө Засах Орон нь Хятадын умард хэсэгт Монгол, Орос улстай 4221 км урт шугамаар хиллэдэг. Үүнээс Монгол Улстай 3211 км шугамаар хиллэдэг нь нийт хилийн шугамын уртын 76%-ийг эзэлдэг. Хил дагуу Манжуур, Эрээн зэрэг 18 нээлттэй боомт байдаг ба төмөр зам, автозам, усан зам болон агаарын зам зэрэг олон төрлийн тээвэр бүхий цогц бүрэлдэхүүнтэй чөлөөт бүсийн загварыг буй болгосон байна.

Өвөр Монголын Өөртөө Засах Орон 1.183 сая хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, 2017 оны эцсийн байдлаар хүн амын тоо 25 сая 286 мянгад хүрч, хотжилт 62 хувьтай байна. 2017 онд Өвөр

“Нэг бүс, нэг зам”-ын хүрээнд Өвөр Монголоос Монгол Улсад хийсэн хөрөнгө оруулалт, худалдааны тухайд

Монголын ДНБ 1610.3 тэрбум юань болж, жилд 4%-аар өссөн байна. Нэг хүнд ногдох ДНБ 63386 юаньд хүрчээ. Өвөр Монголын зүүн талаар Хянганы нуруу, Хөлөнбуйрын их тал, баруун зүгт Алашаа говь, төв хэсгээр Шилийнголын их тал, Ордосын өндөрлөг, Бор тохойн уудам хөндий оршино.

Энэхүү нутагт ой шугуй, тал хээр, тариалангийн талбай, олон зүйл зэрлэг амьтан, өвс ургамал элбэг бөгөөд газрын хэвлийн нөөц баялаг ихтэй болохоор “Зүүн талын ой, баруун талын төмөр, өмнө зүгийн амуу, умар зүгийн мал сүрэг, газар сайгүй ашигт малтмалын орд” хэмээн нэрлэгддэг.

Монгол Улс

Монгол Улс нь Хятад, Оросын дунд оршдог ба далайд гарцгүй дэлхийн хоёрдахь том улс юм. 1561100 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй. Нийт 3.2 сая хүн амтай, нэг хавтгай дөрвөлжин километр нутагт 2 хүн ногддог ба хүн амын нягтрал хамгийн бага улсын нэг юм. Хүн амын бараг тал хувь нь нийслэл хотдоо төвлөрсөн, хотжилтын түвшин 66.2 хувьтай.

Монгол Улс нь газрын дээрх болон газрын хэвлийн нөөц баялаг ихтэй, ялангуяа 1.3 их наяд доллараас давсан дэлхийн хэмжээний орд болохуйц нүүрс, зэс, алт, төмрийн хүдэр, газрын тосны орд зэрэг нөөц баялаг нь олон улсын анхаарлын төвд байдаг. Уламжлалт бэлчээрийн мал аж ахуй нь эдийн засгийн үндэс суурь бөгөөд 2017 оны эцсийн байдлаар малын тоо толгой 66 сая гаруй болж, нэг хүнд ногдох хэмжээгээр дэлхийд тэргүүлж байна. 2017 онд Монгол Улсын ДНБ 11.488 тэрбум доллар, нэг хүнд ногдох орлого 3735 ам.доллар байна.

2. Өвөр Монголоос Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт, худалдааны байдал

Өнгөрсөн 20 жилд БНХАУ нь Монгол Улсын хамгийн том худалдааны түнш бөгөөд хөрөнгө оруулалтын томоохон эх үүсвэр

болсон юм. Харин Өвөр Монгол болон Монгол Улсын хоорондох хөрөнгө оруулалт, худалдааны хамтын ажиллагаа нь хоёр улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг болж байна.

1) Өвөр Монгол, Монгол Улс хоорондын хоёр талт худалдаа

1980-аад оны сүүлчээс эхлэн Өвөр Монгол, Монгол Улсын хооронд хилийн худалдаа эхэлсэн бөгөөд хоёр талын худалдааны хэмжээ Хятад-Монголын нийт худалдааны хагасаас илүү хувийг эзэлдэг. Өвөр Монгол, Монгол Улсын хоорондох худалдаа нь харилцан нөхсөн шинжтэй бөгөөд Монгол Улсаас голлон нүүрс, зэс, түүхий нефть, төмрийн хүдэр, цайрын хүдэр, малын гаралтай түүхий эд зэргийг импортолдог бол Монгол Улс руу барилгын материал, ган төмөрлөг, бөс даавуу, өргөн хэрэглээний бараа, жимс, хүнсний ногоо зэргийг экспортолж байна.

2012 оноос Монгол Улс Өвөр Монголын худалдааны хамгийн том түнш болжээ. 2017 онд Өвөр Монголын нийт импорт, экспортын хэмжээ 94.24 тэрбум юаньд хүрснээс зөвхөн Монгол Улстай хийсэн экспорт, импортын худалдаа 26.46 тэрбум юань болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42.2%-аар өсчээ. Энэ нь Өвөр Монголын нийт импорт, экспортын 28.1%-ийг эзэлж байгаа бөгөөд Монгол Улс Өвөр Монголын өөртөө засах орны томоохон худалдааны түнш улс хэвээр байгааг харуулж байна.

2) Монгол Улс дахь Өвөр Монголын хөрөнгө оруулалт

1989 оноос Өвөр Монгол, Монгол Улс хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа эхэлжээ. Монгол Улс дахь хөрөнгө оруулалт нь Өвөр Монголоос гадагшаа чиглэж буй нийт хөрөнгө оруулалтын 55% -ийг эзэлж байна.

2012 онд Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах тухай хууль батлагдсанаас хойш Өвөр Монголын хөрөнгө оруулалт

“Нэг бүс, нэг зам”-ын хүрээнд Өвөр Монголоос Монгол Улсад хийсэн хөрөнгө оруулалт, худалдааны тухайд

нэлээд буурах хандлагатай байсан бол 2013 оны эцсээр Монгол Улс хөрөнгө оруулалтын шинэ хуулийг хэрэгжүүлж эхэлснээр эрс өссөн байна.

2014 онд Өвөр Монголоос Монгол Улсад хөрөнгө оруулах 19 төсөл хэрэгжиж, 350 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр тохиролцсон нь өнгөрсөн оныхоос дөрөв дахин өссөн байна.

2014 оны эцэс хүртэл Өвөр Монголоос Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжийн тоо 113 болсон² бөгөөд уул уурхай, дэд бүтэц, барилга байгууламж, газар тариалан, мал аж ахуй, худалдаа, хоол хүнсний үйлчилгээ, барилгын инженерчлэл болон барилгын материалын үйлдвэрлэл зэрэг салбарт өргөжин тэлжээ. Тэдгээрийн дотроос хөрөнгө оруулалтын 60 гаруй хувь нь геологи, уул уурхайн салбарт төвлөрч байна.

2015 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан Өвөр Монгол, Монгол Улсын хөрөнгө оруулалт, худалдааны үзэсгэлэн яармагт хоёр орны аж ахуйн нэгжүүд худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны 400 сая ам.долларын³ 19 гэрээнд гарын үсэг зурсан байна. Эдгээр гэрээ нь агаарын тээвэр, уул уурхай, авто зам, сэргээгдэх эрчим хүч, хөдөө аж ахуй зэрэг өргөн хүрээг хамарсан байдаг.

2015 оны 10 дугаар сард Хөх хотод болсон Монгол-Хятадын анхны үзэсгэлэн яармагт 166 төрлийн хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээ 148.59 тэрбум юань байв.

2016 оны эхний хагаст Өвөр Монголоос Монгол Улсад хөрөнгө оруулсан 16 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэн бөгөөд БНХАУ-ын гэрээний нийт хөрөнгө оруулалт 52.484 сая ам.долларт хүрч, өмнөх жилээс 64.9%-иар буурчээ. Хөрөнгө оруулалтын салбар нь хөдөө аж ахуй, мал аж ахуй, уул уурхай, үйлдвэрлэл, мэдээлэл

² 王国英：“蒙古国在呼和浩特推介肉制品”，《内蒙古日报》2015年5月20日。

³ 郑闯：“内蒙古和蒙古国投资贸易洽谈会签约超4亿美元”，新华网，2015年6月9日。

холбооны үйлчилгээ, жижиглэн худалдаа, тээвэр, үл хөдлөх хөрөнгө зэрэг байна.

2017 оны 9 дүгээр сард Хөх хотноо болсон Монгол-Хятадын хоёрдугаар үзэсгэлэн худалдааны үеэр талууд нийт 88.143 тэрбум юаний хөрөнгө оруулалттай хамтын ажиллагааны 47 гэрээ, санамж бичигт гарын үсэг зуржээ. Эдгээрийн дотор Хятад-Европыг холбосон төмөр замын хамтын ажиллагааны 6 гэрээнд гарын үсэг зурсан байна. Үзэсгэлэнгийн үеэр яригдсан санамж тохиролцоогоор худалдааны хэмжээ бараг 530 сая юаньд хүрсэн байв.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсад хөрөнгө оруулсан Өвөр Монголын хөрөнгө оруулалтад улсын өмчит томоохон аж ахуй харьцангуй цөөн, дийлэнх нь жижиг, дунд аж ахуй, хувийн хэвшлийнхэн байсан тул хүчин чадал хязгаарлагдмал, хөрөнгө оруулалтын хэмжээ бага байна. Одоо байгаа 25 уул уурхайн компаниас хагас хүрэхгүй хувь нь 100 гаруй ажилтантай. Өвөр Монголд бүртгэлтэй 200 орчим аж ахуйн нэгж Улаанбаатар хотод байгаагийн 90 орчим нь Монгол-Хятадын хамтарсан үйлдвэрүүд юм. Үүнээс 1/3 нь ашигтай, 1/3 нь статус кво байдалтай, 1/3 нь алдагдалтай ажиллаж байна⁴. Монголын талаас Хятадын талд хүч чадалтай, дэвшилтэт техник технологи, чанартай боловсон хүчинтэй аж ахуй нэгж байгуулж, байгаль экологийн орчныг хамгаалах талаар хатуу шаардлага тавьж байна.

3. Хөрөнгө оруулалт, худалдааны эрх зүйн эрсдэлийн үнэлгээ

Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, түүний эрсдэл

1. Монгол Улс улс төр, эрх зүйн орчноо тогтвортой, залгамж холбоог нь сайжруулах шаардлагатай байна. Уг нь Монгол Улс гадаад, дотоод эрх зүйн орчин сайтай байсан бөгөөд 1990-ээд оны эхээр “Хөрөнгө оруулалтын баталгааны тухай Сөүлийн конвенц” болон “Улс орны болон иргэд хоорондын хөрөнгө

⁴ 哈斯巴特尔、刘巴特尔：“内蒙古企业对蒙投资现状与对策建议”，中国蒙古国研究会成立30周年学术研讨会论文，2014年12月，呼和浩特。

оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай Вашингтоны конвенци”-д нэгдэн орсон ажээ. Тухайн улсын гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулагчдад зориулсан татварын хөнгөлөлтийг заасан байдаг. Тухайлбал, эрчим хүч, тээврийн дэд бүтэц, харилцаа холбооны аж ахуйн нэгжүүд нь 10 жил орлогын албан татвараас бүрэн чөлөөлөгдөж, дараагийн 5 жилд хагас татвар ноогдуулдаг. Монгол Улсын Засгийн газар тогтвортой байдлын гэрээндээ 2 сая доллараас дээш хөрөнгө оруулалтад 10 жилийн хугацаанд татварын бодлого өөрчлөгдөхгүй, 10 сая доллараас дээш хөрөнгө оруулалт хийсэн бол татварын тогтвортой байдлын хугацаа 15 жил хүртэл үргэлжилнэ гэж заасан байдаг ч Монгол Улсын хууль эрх зүйн орчин тогтворгүй, залгамж холбоо дутмаг, аж ахуйн нэгжүүд баталгаагүй, хөрөнгө оруулагч компаниуд болон хувь иргэний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хуулиар хамгаалж чадахгүй байна. Жишээлбэл, 2012 оны 5 дугаар сард УИХ-аас “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль”-ийг баталсны дараа 2013 оны эхээр хоёр улсын Засгийн газраас баталсан гэрээг Монгол Улсын нүүрсний компаниуд түдгэлзүүлж, нүүрсний үнийг өсгөхийг шаардаж, Өвөр Монгол руу нүүрс гаргахыг зогсоосноос болж Хятад, Монгол хоёр талын туншүүдэд ноцтой хохирол учруулсан байна. Энэ мэт эдийн засгийн бус хүчин зүйлс нь хоёр талын хөрөнгө оруулалт, худалдааны хамтын ажиллагаанд асар их саад тоггор учруулж байна.

2. Эдийн засгийн бус хүчин зүйл. 2010 оны 7 дугаар сард “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ыг шинэчлэн найруулж, гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь хэмжээг гадны хөрөнгө оруулалтын 30%-аас хэтрэхгүй байх бодлого баримтална гэж заасан байна. Нэгэн үе Монгол Улс дахь гадаад хөрөнгө оруулалтын 50-иас илүү хувийг БНХАУ эзэлж байсан нь байх

ёстой 30%-аас хэтэрсэн байв. Энэ үзэл баримтлалын дагуу 2012 онд Монгол Улс гадаад хөрөнгө оруулалтыг хязгаарласан хууль хэрэгжүүлснээр Хятадын болон гадаадын хөрөнгө оруулалт эрс буурч, 2015 онд анх удаа гадаадын хөрөнгө оруулалт сөрөг дүнтэй гарчээ.

3. Байгалийн эрс тэс уур амьсгалтай, дэд бүтэц муу хэвээр байна. Уул уурхайн хамтын ажиллагааны салбарт Монголын дэд бүтэц хоцрогдсон төдийгүй, зарим уурхай усны нөөц, эрчим хүчний хомсдолтой, зам тээврийн хүндрэлтэй нөхцөл зэрэг нь Хятадын аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтын эрсдэлийг ихээхэн нэмэгдүүлж байна.
4. Монгол Улсын геологи хайгуулын чадамж өндөр биш, тоног төхөөрөмж нь хуучирсан, найдвар муутай тул хятадууд геологи хайгуулын хэрэглэгдэхүүнээ баталгаажуулахын тулд дахин геологийн шинжилгээ хийх шаардлагатай байдаг нь эхэн үеийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд хүргэжээ.
5. Монгол Улс байгалийн баялгийг нээн ашиглахдаа түүхий эдийг экспортлох сонирхолгүй байгаа бөгөөд боловсруулсан эцсийн бүтээгдэхүүн болгож, нэмүү өртөг бүхий экспортыг дэмжиж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдээс техникийн дэмжлэг авах хүсэлтэй байгааг харуулж байна.

БНХАУ-ын талд буй асуудлууд

1. БНХАУ-ын Монгол дахь хөрөнгө оруулалтын гол асуудал нь том хэмжээний хөрөнгө оруулалт цөөн, ихэнх нь хүчин чадал муутай жижиг, дунд аж ахуй нэгж, хувийн хэвшлийнхэн байгаад оршино. Хамтын ажиллагааны чиглэлүүд нь явцуу, ур чадвар муу, шатлал доогуур тул эдийн засгийн үр өгөөж хумигдмал байна. Энэ мэтээс болж газар зүй, эдийн засгийн харилцан нөхсөн давуу талууд нь ч дорвитой хөгжиж чадахгүй байна.

2. Хятадын тал Монголын хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомж, дүрэм журмын талаар ойлголт муутай байдгийн дээр Монгол Улсын бодлого, хууль тогтоомж нь тогтворгүй байдаг. Зарим хөрөнгө оруулагч компаниуд хөрөнгө оруулах төслүүддээ техник, эдийн засгийн нарийвчилсан шинжилгээ хийдэггүй, түншлэгчийнхээ талаар ойлголт муу, хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны эрсдэлийг бүрэн гүйцэд тооцоолоогүйгээс болж ноцтой хохиролд учрах эрсдэлийг дагуулж байдаг.
3. Хятадын компаниудын эмх замбараагүй өрсөлдөөн, дүрэм журамгүй үйл ажиллагаа нь хоёр талын үр дүнтэй хамтын ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна. Мөн монголчуудын хятадуудад хандах хандлага таатай бус тул хятадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллагууд болон хятад ажилтнууд монголчууд дахь өөрсдийн үнэлэмжээ дээшлүүлэх шаардлагатай.
4. Олон улсын түвшинд, Монгол Улсын газрын дээрх болон газрын хэвлийн баялаг нь Монгол Улсын “гуравдагч хөрш” болох Япон, Канад, ОХУ, Австрали, АНУ, Солонгос зэрэг улсын сонирхлыг ихээхэн татаж байна. Тиймээс Өвөр Монгол, Монгол Улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаанд олон боломж бололцоо байхын зэрэгцээ сорилт, бэрхшээлтэй асуудлууд ч мөн тулгарч байна.

Арга зам, зөвлөгөө

Хэдийгээр Өвөр Монгол, Монгол Улс нь хөрөнгө оруулалт, худалдааны талаар дотоод, гадаадын олон асуудалтай тулгараад байгаа ч “Нэг зам, нэг бүс”, “Хөгжлийн зам” санаачилгуудыг хэрэгжүүлэх, Монгол-Хятад-Оросын хамтарсан эдийн засгийн коридор байгуулахад Өвөр Монгол, Монгол Улсын хамтын ажиллагаа зайлшгүй чухал хүчин зүйл болох нь дамжиггүй. Иймийн тулд бид, хоёр талын нийтлэг эрх ашгийг төлөөлсөн эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг улам

өргөжүүлэхийн тулд 2014-2018 оны хооронд хоёр улсын байгуулсан 73 хэлэлцээрийн хүрээнд эдгээр тусгай хөтөлбөрүүдийг идэвхтэй хэрэгжүүлэх ёстой. Цаашид үр дүнтэй хамтран ажиллахын тулд дараах арга хэмжээг авахыг санал болгож байна. Үүнд:

1. Хоёр талын засгийн газрын үйл ажиллагааны гүйцэтгэх үүргийг сайжруулах

БНХАУ-ын талаас Засгийн газар нь хамтын ажиллагааны үр ашигтай, найдвартай байдлыг хангахын тулд цогц төлөвлөгөө боловсруулж, төрийн өмчит болон хувийн том, дунд аж ахуй нэгжүүдийн Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх, хамтын ажиллагааны үр ашиг, итгэлцлийг баталгаажуулах шаардлагатай.

Монголын талаас Засгийн газар нь гол удирдамжаа сайжруулж, төрийн бодлого, хууль тогтоомжоо төгөлдөржүүлж, ялангуяа хуулийн тогтвортой, залгамж холбоог хангаж, гадаадын хөрөнгө оруулагчдад таатай орчныг бүрдүүлэх ёстой. Баярлууштай нэг зүйл бол Монгол Улсын их хурлын дарга М.Энхболд 10 дугаар сарын 1-ний намрын ээлжит чуулганы нээлтийн үеэр хэлсэн үгэндээ: “Дотоодын бизнесийн орчныг сайжруулах, төрийн ажлын үр ашгийг дээшлүүлэх” хэрэгтэй байгааг онцлон тэмдэглэв.

Бид Монгол Улсын хөрөнгө оруулалт, бизнесийн орчин аажмаар сайжирна гэдэгт итгэж байна. Тиймээс, ирээдүйд хоёр талын аж ахуйн нэгжүүд зах зээлийн зарчмаар, эрх тэгш зөвшилцөх замаар хоёр улс засгийн газрын түвшинд хамтран баталсан гэрээ байгуулж, аливаа хүндрэл бэрхшээлийг үл харгалзан гэрээгээ хүчин төгөлдөр биелүүлэх хэрэгтэй. Үр ашгийг хамтдаа хүртэж, эрсдэлийг ч хамтдаа үүрье.

2. Тухайн газарт нь судалгаа хийж, найдвартай мэдээлэл авах

Монгол орны геологи хайгуулийн мэдээлэл учир дутагдалтай байдаг. Тиймээс ашигт малтмалын нөөцийн бодит байдлыг сайтар ойлгохын тулд хоёр талын геологи, уул уурхайн салбарынхан

Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрөл авч, Монголын талын геологи хайгуулын мэдээ баримт, бусад холбогдох зүйлсийг дүгнэн шинжилж, аж ахуй нэгжүүдтэй хамтран судалгаа шинжилгээ хийх хэрэгтэй. Ингэснээр Монголын уул уурхайн хайгуул, зам тээвэр, ус, цахилгаан, тээврийн хүчин чадал зэргийг нягтлан судалж тогтоон аж ахуй нэгжүүдэд байгалийн баялгийг нээн ашиглахад хэрэг болох найдвартай мэдээллээр хангаж өгөх юм.

3. Хамтын ажиллагааны арга замыг боловсронгуй болгож, Монгол Улсын аж үйлдвэрийн салбарын шинэчлэлийг дэмжих

Хятадын тал байгалийн баялгийг Монголоос шууд импортлох байдлаа аажмаар өөрчилж, боловсруулах болон эцсийн бүтээгдэхүүн болгох хөрөнгө оруулалт, худалдааг хослуулсан олон талт хамтын ажиллагааны арга замыг эрэлхийлж байна. Хамтын ажиллагааны хандлага бид харилцан ашигтай, харилцан үр дүнтэй, Монгол Улсын эдийн засгийн хөгжил, үйлдвэрлэлийн шинэчлэлд тус нэмэр болохуйц, цаашлаад бие даан хөгжих чадвараа нэмэгдүүлэхэд нь анхаарах хэрэгтэй. Хятадын талаас Монголын нүүрсний орд газар дахь эцсийн бүтээгдэхүүн болгох, боловсруулах үйлдвэрлэлийн гинжин холбоог өргөжүүлж, нэмүү өртөгт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх талаар идэвхтэй туслалцаа үзүүлэх хэрэгтэй.

4. Монгол Улсын байгалийн баялгаа худалдах замыг тэлэх

Далайд гарцгүй Монгол орны хувьд байгалийн баялгаа ашиглахад тохиолдож буй гол саад бэрхшээл нь тээвэр юм. Газарзүйн давуу талаас нь авч үзвэл, Хятад улс нь Монголын өмнөд хэсэгт орших томоохон уурхайнуудын хамгийн ойр зах зээл болох юм. Жишээлбэл, Таван толгойн уурхай нь Хятадын боомтоос ердөө 270 км зайд оршиж байна. Үйл ажиллагаагаа эхэлсэн Таван толгойн уурхайгаас Гашуунсухайт (Хятадын Ганц мод боомт) хүртэл тавигдах олон улсын стандарт төмөр зам бригдаж дуусвал хоёр улсын тээвэр зуучийн хамтын ажиллагаанд ихээхэн тус нэмэр болохын сацуу,

Монголын байгалийн баялгийг Хятадын далайн боомтын тээврийн системд түшиглэн Зүүн хойд Ази хүртэл тээвэрлэх, худалдаалах замыг тэлж өгөх юм.

5. Байгаль орчноо хамгаалахад анхаарлаа хандуулах

Монголчууд бол байгаль дэлхийгээ шүтэн дээдэлдэг үндэстэн. Монгол Улс бол дэлхийд нэн ховор нүүдэлчин соёлтой бөгөөд оршин амьдрах үндэс нь нутаг бэлчээр юм. Уул уурхай бол бэлчээрийн эко системд асар их сөрөг нөлөө үзүүлдэг тул Хятадын зүгээс Монгол Улсын байгаль орчныг хамгаалах асуудлыг нэн тэргүүнд тавьж, орон нутгийн иргэдийн эрх ашигт баталгаа гарган, олборлосон талбайг нөхөн сэргээж, экологийн тэнцвэрийг хадгалах талаах анхаарах шаардлагатай байна. Мөн бид бүхэн Монголын нүүдлийн соёл иргэншлийг хамгаалах ёстой.

6. БНХАУ-Монгол Улсын эдийн засгийн хамтын ажиллагааг бүс нутгийн интеграцад нэгтгэх

Өрсөлдөөн дэх гадны хүчин зүйлсийг бодитоор даван туулахын тулд, хоёр улсын хоорондох эдийн засаг, худалдааны хүрээг өргөжүүлж, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, бүс нутгийн интеграцчиллын явцтай нэгтгэх шаардлагатай. Хятад улс нээлттэй, уужуу байдлаар Монгол Улсын нөөц баялгийн зах зээл дээр бусад улс орны адил эрх тэгш өрсөлдөн, туршлага, техник технологийн мэдлэг чадвараа солилцох нь чухал. Олон талт хамтын ажиллагаа, ил тод байдлыг ханган ажиллах нь Монгол Улсын ямар нэгэн улс орноос хамааралтай болох айдсыг багасгахад илүү тустай.

7. Нийгмийн хариуцлагыг идэвхжүүлэх, орон нутгийн ард иргэдийн эрх ашигт баталгаа гаргах

Хятадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд нь орон нутгийн аж ахуйн нэгж, боловсон хүчинтэй хамтран ажиллаж, тухайн орон

нутгийн ажлын байрыг нэмэгдүүлэн эдийн засгийн хөгжлийг дэмжих замаар нийгмийн хариуцлагаа идэвхийлэн хүлээн авч, орон нутгийн иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, сайжруулахад анхаарах хэрэгтэй.

Хоёр тал эдийн засаг, худалдааны үр ашигтай хамтын ажиллагаагаар дамжуулан, харилцан ээлтэй, үр ашигтай иж бүрэн холбоо тогтоож чадах юм. Үүний зэрэгцээ Монгол Улсын нийгэм эдийн засгийг зэрэгцүүлэн хөгжүүлэх, Монгол Улсын ард түмэнд бодит үр өгөөжийг бий болгох шаардлагатай байна. Тухайлбал, зам тавих, цэцэрлэг, сургууль, номын сан, соёл урлаг, спортын байгууламж барьж, Монголын ард түмний Хятадын талаарх сөрөг сэтгэгдлийг арилгах нь нэн чухал. БНХАУ нь Монгол Улсын итгэлтэй, найдвартай, хариуцлагатай стратегийн түнш мөн гэсэн итгэлцлийг бий болгох хэрэгтэй.

8. Монгол Улсад ирж буй хятадын ажиллах хүчний сургалтыг бэхжүүлэх

Хятадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хоорондох эмх замбараагүй өрсөлдөөн зэрэг нийгэмд сөрөг нөлөөтэй зүйлс нь зөвхөн хоёр талын эдийн засгийн ашиг сонирхолд хохирол учруулаад зогсохгүй хятадын аж ахуйн нэгж, хятад хүний үнэлэмж буурах гол шалтгаан болдог. Зөвхөн нэг хятад хүний үг хэл, үйл хөдлөл тэр чигээрээ хятад орныг төлөөлж байдгийг мартаж болохгүй. БНХАУ-ын зүгээс Монгол Улсад ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийн удирдлагад хатуу шаардлага тавьж, хилийн дээс давахаас нь эхлээд Монгол Улсын үндсэн нөхцөл байдал, соёл, ёс заншил, хууль журмыг сайтар таниулах сургалт явуулж, гадаад улсад явахдаа харилцан соёл, ёс заншлыг хүндэтгэн, биеэ соёлч боловсон авч явахыг сургах нь зүйтэй.

2010 оны 8 дугаар сард БНХАУ-ын тусламжийн барилгын төслийн ажилчид, Монгол ажилчдын хооронд мөргөлдөөн гарч байв. Дахин ийм үл ойлголцол, зөрчил маргаан гаргахгүйн тулд гадаад

дахь ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн талаарх сургалтыг сайжруулан, хөдөлмөрийн чадвар, хэл, харилцааны ур чадвар, хувь хүний үзэл ухамсрыг дээшлүүлэх хэрэгтэй.

DOI: <https://doi.org/10.5564/jis.v0i1.1120>

Evaluation and recommendation on Inner Mongolian FDI to Mongolia in the framework of “One Belt, One Road”

Naran (Nalin).

*Sc.D, Professor, Researcher Center of Mongolian Studies,
Inner Mongolia University.
E-mail: ndnal@sina.com*

Abstract. *The Inner Mongolian Autonomous Region plays an important role in the development of bilateral ties between Mongolia and it borders on mountains with Mongolia. The bilateral economic and trade cooperation between Inner Mongolia and Mongolia weighed position in the framework of China’s “One Belt, One Road” strategy and Mongolia’s “Road Development” initiative. The article aims to assess the situation of Inner Mongolia Autonomous Region and Mongolia, the current investment situation of the two countries, the risks of bilateral cooperation, and the advice of the consultant on ways to improve it.*

Key words: *investment from Inner Mongolia to Mongolia, One Belt, One Road Collaboration, Investment Assessment, Cooperation Risks*